



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/16

Хэрлэн сум

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, 29.1.5-ын "а", Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх" дэд хөтөлбөрийн хүрээнд Хэнтий нутгийн зохиолч, яруу найрагчдын "Хан Хэнтийн салхи" номын хэвлэлийн зардалд зориулан 15.000.000 /арван таван сая/ төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА